



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 22-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хурал: 2022 оны 04 сарын 22-ны өдрийн 14.00 цагт Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн тойруу-132 тоот хаягт байрлах Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрийн оффисоос **Join Zoom Meeting** <https://us05web.zoom.us/j/83737948318?pwd=UitwZIRIbzBLNzlQU2JFVWVnUXUwZz09> линкээр Meeting ID: 837 3794 8318, Passcode: 898068 холболтыг ашиглан цахим болон танхим хосолсон хэлбэрээр хийсэн. Хурлын ирц бүртгэл санал хураалтыг hural.basaltwool.mn цахим хуудас ашиглан явуулсан болно.

Хуралын ирц: Хуралд нийт 41,604,837 ширхэг хувьцаа эзэмшиж буй 25 хувьцаа эзэмшигч оролцсоноос 21 хувьцаа эзэмшигч **Join Zoom Meeting** холбоосоор цахим хэлбэрээр, 4 хувьцаа эзэмшигч танхим хэлбэрээр тус тус оролцсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурал хүчин төгөлдөр болсон тухай Тооллогын комиссын 2022.04.22-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг Тооллогын комиссын дарга Ц.Байгальмаа уншиж танилцуулав.

Ц.Байгальмаа: Монгол базалт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол 2022.04.22-ны өдөр, Дугаар 1. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасныг үндэслэн Бүртгэлийн өдөр буюу 2022.04.03-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн сангаас авсан мэдээллээр нийт хуралд оролцох эрх бүхий 2342 иргэн, аж ахуйн нэгжийн 56,417,000 ширхэг хувьцаа байгаагаас өнөөдрийн хуралд 41,604,837 ширхэг хувьцаа эзэмшиж буй 25 хувьцаа эзэмшигч оролцсон нь нийт саналын эрхтэй хувьцааны 73,75%-тай тэнцүү байх тул хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

Хэлэлцэх асуудал:

1. Монгол базалт ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Хурлын дарга А.Энхгэрэл: Сайн байцаана уу. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Та бүхэнд Компанийн 2021 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2022 оны Бизнес төлөвлөгөө зэргийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд нэгтгэн брокер, диллерийн компаниар дамжуулан хүргүүлсэн. Мөн компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудасаас нээлттэй мэдээлэл авах боломж байгаа. Өнөөдрийн хурал дээр товчхон танилцуулга хийе гээд Санхүүгийн гол үзүүлэлтүүд болон онцлох үйл ажиллагааг бэлтгэсэн presentation-ийн дагуу танилцууллаа.

Харагдах байдал товч:



Тайлант хугацаанд Монгол базальт ХК-ийн хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 249,53 төгрөг, доод ханш нь 160,11 төгрөг байсан бол, 2021 оны хаалтын ханш 172,41 төгрөг байсан. 2021 оны ашигт ажиллагааны үр дүнгээр нэгж хувьцаанд 17.09 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Компани өнгөрсөн онд удирдлага санхүүгийн 26, инженер техникийн ажилтан 17, үйлдвэрийн ажилтан 32 нийт 75 ажилтан, албан хаагчидтайгаар ажилласан.

2021 онд бид цар тахлын эрсдлийг даван туулж, зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахын төлөө чармайн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж 3300 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт 582 аж ахуйн нэгж, 1200 гаржй иргэнд худалдсанаас 11,4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. 2020 онд нийт борлуулалтын орлогын 26,3% нь борлуулалт, удирдлагын зардал байсан бол 2021 онд 12,4% болгон бууруулж ажилласан. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд болон компанийг сурталчлан танилцуулах талаар олон төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: 2022 оныг бид их урам зоригтойгоор эхлүүлж байна. 2022 оны 02 сарын 25-ны өдөр Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн байгууллага болох ЭСКО тусгай зөвшөөрлийг авсан байгаа. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр олон ажил зохион байгуулахаар 2022 оны Бизнес төлөвлөгөөнд тусгасан. Мөн 2022 онд хаалттай бонд гаргахаар судалгаа, шинжилгээний ажлууд хийгдээд явж байна. Бид 2022 онд нийт 7000 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулна гэж төлөвлөсөн ба энэ нь ойролцоогоор 30 орчим тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллана гэсэн үг. Үйлдвэрлэлийн хүчин чадал болон зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан энэ төлөвлөгөөг биелүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байгаа гэснээр 2022 оны Бизнес төлөвлөгөөг товч танилцуулав.

Дүгнэлт болон бизнес төлөвлөгөөтэй холбоотой асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигч Сүхболд: 2021 хаалтын байдлаар чулуун хөвөн дулаалгын зах зээлд монголбазалтын эзлэх хувь хэмжээ? Анх IPO гарснаас хойш зах зээлд эзлэх хувь хэмжээ дундажаар хэдэн хувиар өсч байна?

А.Энхгэрэл: Бидний тооцоолж байгаагаар 2021 онд дулаалгын материалын зах зээл 90 орчим тэрбум төгрөг байсан гэж үзэж байна. 11,4 тэрбум төгрөгийн борлуулалт бол дотоодын зах зээлийн 20 орчим хувийг эзэлж байгаа. 2022 оны бизнес төлөвлөгөөгөөр дотоодын зах зээлийн 50 хувьд хүрч ажиллана гэж байгаа. ИРО гарсанаас хойш зах зээлд эзлэх хувь 5 хувь байсан бол өнөөдрийн байдлаар 20 орчим хувь эзэлж байгаа нь цаашид ч нэмэгдэх ирээдүйтэй гэж харж байна.

Хувьцаа эзэмшигч Тулгаа: Орос улсад салбар нээнэ гэсэн больсон юм уу?

А.Энхгэрэл: Орос Украины дайнаас шалтгаалан бид түр хойшлуулсан. Түүнээс биш энэ зорилгыг болихгүй. Дотоодод үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний үйлдвэрлэгч нар, тэр дундаа барилгын материал үйлдвэрлэгч нар экспорт хийх нь ашиггүй гэж үзэж байгаа. Наад зах нь ОХУ-ын импортын татвар 25 хувь байдаг, энэ нь манай бүтээгдэхүүний үнэ дээр 25% нэмэгдэнэ гэсэн үг юм. Тэгэхээр ОХУ-д салбар байгуулж ажиллах нь ашигтай хувилбар юм. Үүнийг бид нэг том амжилт, нэг том төлөвлөгөө гэж харж байгаа. ОХУ-ын санкцууд гайгүй болж, геополитикийн өөрчлөлтүүд хийгдэхээр хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа. Манай үйлдвэр технологи болон хүн хүчний хувьд боломжтой байгаа бөгөөд энэ төлөвлөгөөг эхлэх үед илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжтой.

Апекс капитал ХХК-ийн төлөөлөгч: 2022 онд 7 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд одоо байгаа үйлдвэрийн хүчин чадал хангалттай юу? Эсвэл энэ жил үйлдвэр дээр дахин сайжруулалт хийгдэх үү?

А.Энхгэрэл: Маш зөв асуулт байна. Гэхдээ 2022 онд 7000 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн хангалттай. Энэ нь үйлдвэр 100 хувь хүчин чадлаараа ажиллана гэж төлөвлөөгүй тоо шүү. Үйлдвэрлэлийн хүчин чадал гэхээс илүү зах зээлийн багтаамж, түүхий эд материалын нөөцлөлт, валютын ханш, инфляци зэрэг бусад гадаад хүчин чадалтай хамааруулан 7000 тонн гэж эрсдэл багатайгаар төлөвлөсөн байгаа. Одоогийн төлөвлөж байгаагаар үйлдвэрт томоохон капитал шинэчлэлт хийхгүй. Гэхдээ хайлуулах үйлдвэрийн онцлог, бүтээмж өндөртэй технологийн инноваци шинэчлэлтийн ажил байнга хийгдэх ёстой байдаг. Үүний хүрээнд бид хүн хүчний мэргэжил мэдлэгийг сайжруулах, гадаадын мэргэжилтэн урьж ажиллуулах, хоцрогдсон жижиг эд ангиудын өөрчлөлт, засвар байнга хийгддэг гэдгийг ойлгоорой. Төлөвлөсөн томоохон шинэчлэлт 2023 оны сүүлийн хагас жилд хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Соёлгэрэл: Үйлдвэрлэл 100% явж байгаа бол борлуулалт хэдэн хувьтай явж байна вэ... ямар мартетинг хэрэгжүүлж байнаа вэ... Арматур үйлдвэрлэл явуулж эхлэх гэж байгаа юм байна... нийт борлуулалтын хэдэн хувийг эзэлнэ гэж төлөвлөсөн бэ?

А.Энхгэрэл: Үйлдвэр цагт 1,7 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа, нэгдүгээр улирлын байдлаар 2,4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Энэ жилийн эхний улирлын төлөвлөгөөний 80 хувийг хангасан ба зөрүүг нь хоёрдугаар улиралд нөхөх боломжтой. Арматур үйлдвэрлэл бол энэ оны 6 сард зах зээлд нийлүүлнэ гэж тооцон ажиллаж байна. Базальт вайбар арматурын хувьд галд тэсвэртэй, химийн урвалд ордоггүй, Ган арматурыг бодвол хөнгөн, барилга хийцийн технологид нилээд ашигтай бүтээгдэхүүн байгаа. Монгол улсад өмнө нь базальт арматурыг хэрэглэж байсан туршлага байхгүй тул бид нар зах зээлд танилцуулах, сургалт, зааварчилгаа өгөх, стандарт батлуулах, боловсруулах зэрэг шат дараатай арга хэмжээ авагдаж байна. Энэ нь үндсэн борлуулалтыг 10-15 хувь нэмэгдүүлэх боломжтой бөгөөд эхний жилд 1000 тонн шугам угсарсан байгаа.

Апекс капитал ХХК-ийн төлөөлөгч: Бүтээгдүүн үйлдвэрлэлд ямар түүхий эдийг гаднаас авдаг вэ? Хилийн хоригтой холбоотой тасалдал үүсэх нөхцөл байдаг уу?

А.Энхгэрэл: Үндэсний үйлдвэрлэгч нарт тулгарч байгаа хамгийн том эрсдэл бол хилийн хориг. Манай хувьд үйлдвэрийн түүхий эдээс цавуу болон кокосыг гаднаас авдаг. Бидний туршлагаас түүхийн эдийн

тасалдалгүй байдлыг хангах нь чухал гэж үздэг учир нөөцийн бүрдүүлэлтийг сайн хийж байсан, эрсдлийг тооцож 2-3 сарын өмнө татан авалтыг зохион байгуулах ажлыг хийж байсан тул үйлдвэрийг тасралтгүй ажиллуулж чадсан. Цаашид ч энэ хэвээр ажиллана.

Хувьцаа эзэмшигч Сүхболд: Хоёр хөрш улсаас импортоор орж ирдэг чулуун хөвөн дулаалгын материалтай хэрхэн өрсөлдөж (Үнэ? Нийлүүлтийн чадамж, хэмжээ?) байгаа вэ?

А.Энхгэрэл: Хоёр хөршийн импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүний үнэ өдөр тутам өсч байна. Манайх бүтээгдэхүүний үнийг хэт өсөх, хэлбэлзэхээс урьдчилан сэргийлэх, агуулахад байнгын 2 тонн бүтээгдэхүүний нөөцтэй байх бодлого баримталж байгаа. Үнийн хувьд манай бүтээгдэхүүн өрсөлдөх боломжтой.

Г.Соёлгэрэл: Танай чулуун хөвөнгийн дулаалга нь Монгол улсад шинээр баригдаж барилгын дулаалгын хэдэн хувийг нийлүүлж байна вэ? гэсэн судалгаа хийгддэг үү... хэдэн хувь бэ.... иргэд, аж ахуйн нэгжийн чулуун хөвөн дулаалгын талаарх мэдээлэл дутмаг санагддаг олон нийтэд таниулах ямар арга хэмжээ авч байна вэ? Олон нийтэд нээлттэй ХК учраас зах зээлд мэдээлэл түгээх маш их боломж байна гэж танайхыг харж байна.... гэтэл олон нийтэд мэдээлэл хүргэх нь дутмаг санагдаж байна....

А.Энхгэрэл: олон нийтэд мэдээлэл түгээх ажлуудыг шат дараатай явуулдаг. 2020-2021 онуудад үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг эрчимтэй явуулсан. Одоо бүтээгдэхүүний эрэлтийг эрс нэмэгдүүлэх маркетингийн ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Бид гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажилд ач холбогдол өгч байгаа, энэ нь уур амьсгалын болон орчны өөрчлөлттэй холбоотой, түүний эсрэг тэмцэж буй манай компанийн томоохон ажлуудын нэг харж байгаа. Үүнтэй холбоотой бид дулаалгын материалыг хэрхэн зөв сонгох вэ? Дулаалгын материалыг хэрхэн ашиглах вэ? Санхүүгийн хувьд ямар аргаар авах боломжтой вэ гэх сургалтуудыг үнэ төлбөргүй байнгын зохион байгуулдаг. Сургалтын тусгай баг хороодуудтай хамтран тусгайлан зохион байгуулдаг. Монголд баригдаж байгаа барилгуудад хичнээн хувь нь манай бүтээгдэхүүнийг хэргэлж байгаа тухай судалгаа хийгдээгүй. Гэхдээ харьцуулалт хийж гаргах боломжтой, харин бодитой тоо мөн эсэхийг хэлж мэдэхгүй байна.

Хувьцаа эзэмшигч Тулгаа: Энэ жил 28 тэрбумын борлуулалтын орлоготой ажиллана гэсэн. Цэвэр ашиг 4 тэрбум орчим гэж тооцож болох уу?

А.Энхгэрэл: Компани мөн ийм хүлээлттэй байна. Дэлхийн хэмжээнд хамгийн тогтвортой сайн үйл ажиллагаа явуулж байгаа дулаалгын компаниудаас харьцуулж үзэхэд 15 хувийн цэвэр ашигтай ажиллах нь сайн үнэлгээтэй байдаг. Манай хувьд одоогийн байдлаар 10 хувь орчим байна, цаашид нэмэгдэх эсэх нь олон хүчин зүйлээс шалтгаална. Тухайлбал: валютын ханш, инфляци, ажиллах хүчний зардал өсөх гэх мэт

Хувьцаа эзэмшигч Сүхболд: Базалтын чулуун хөвөнг ашиглаж буй томоохон барилгын төслүүдээс дурдах боломж байна уу? FB page дээрээ манай бүтээгдэхүүнийг ийм ийм барилгын төслүүд ашиглаж байна гэж пост оруулбал маш сайн маркетинг болно шүү! Санал: Хувьцааны үнэ болон идэвхижүүлэх тал дээр арай дэндүү муу ажилладаг санагдсан. Бусад Underwriter ууд IPO хийсэн компаниудынхаа гүйцэтгэл болон үр өгөөжийг олон нийтэд нээлттэй танилцуулах, шинжээчид нь удирдлагын багийг нь оролцуулж ярилцах гэх мэт үйл ажиллагаа явуулдаг юм байна лээ шүү. Маргааш гэхэд investment expo 2022 болно. Дараа нь ардын хөрөнгө оруулагч үндэстэн болно. Базалтын underwriter брокер компани арай л чимээгүй байх юм. Тэр хувьцааны групп дээр базалтыг муулахгүй хүн гэж алга. Энэ бүхэн дээр жаахан мэргэжлийн хандаад өгөх хэрэгтэй юм шиг.

А.Энхгэрэл: Базальт чулуун хөвөн ашиглаж байгаа томоохон барилгын төслүүд байгаа. Бид сошиал медиа сайт болон фэйсбүүкээр энэ тухай сурталчилгааг байнга явуулдаг. Барилгын төслүүд өөрсдөө манай

бүтээгдэхүүнийг ашигласан гэж пост оруулах хандлага их байдаг. Одоо миний мэдэж байгаагаар Хадат вилла төсөл, Таван богд компанийн төслүүд байна, Тэсо компанийн төсөлүүд гэх мэт 1000 гаруй том жижиг байнгын харилцагчтай.

А.Энхгэрэл: Дахин асуулт байхгүй тул дуусгаж санал хураалтаа эхлүүлье. Цахим бүртгэлээр саналаа өгөх хугацаа 10 минут байна. Та бүхний гар утсанд санал өгөх нууц үг очсон байгаа. Гар утсаа өгөөгүй хүн байвал чатаар саналаа өгөөрэй.

Тооллогын комиссын дарга Ц.Байгальмаа: Санал хураалтын хугацаа дууслаа. Санал хураалтын дүнг танилцуулъя. 2022.04.22-ны өдрийн Тооллогын комиссын тогтоол дугаар 2- Монгол базальт ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг батлах тухай нийт хуралд оролцсон 25 хувьцаа эзэмшигчийн нийт саналын эрхтэй 41,604,837 хувьцааны 18 хувьцаа эзэмшигчийн 40,651,911 ширхэг хувьцаа зөвшөөрсөн санал, 1 хувьцаа эзэмшигчийн 1178 ширхэг хувьцаа түдгэлзсэн санал өгсөн ба 94,7 хувийн саналаар хүчинтэйд тооцсугай.

Шийдвэрлэсэн нь:

Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол 2022.04.22-ны өдрийн дугаар №

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2021 оны 04 сарын 22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын хэсгийн гишүүн

О.Билгүүн